

“Эгшиглэнт чимээ” хамтлагийн тухай Оросын сэтгүүлч ийн бичжээ



Улаанбаатар хотод зочлох зуур тэнд тайлан тоглолтоо хийхээр Дархан хотоос ирээд байсан “Эгшиглэнт чимээ” хэмээх хvvхдийн хогжмийн хамтлагтай уулзаж, уран бvтээлийг нь сонирхох завшаан тохиов. 15 жилийн тvvхтэй энэ хамтлагийг Монгол улсын гавъяат багш С.Жамъянхорол санаачлан байгуулжээ. Хамтлагийн гишvvд нь долоогоос 16 насны сургуулийн хvvхдvvдээс бvрдэнэ. Энэ хамтлагийн хамгийн хачирхалтай зvйл нь гарын доорх ямар ч зvйлээр гайхамшигтай сайхан хогжмийн зэмсгийг орлуулан тоглож болдогийг харуулсан явдал. Тэдний хогжмийн зэмсэг гэвэл ердоо янз бvрийн хэмжээ, диаметртэй томор савхнуудын /труба/ тайрдас, булан томрvvд /уголка/, модны тайрдас болон зvсмэл моднууд бас шилэн лонх гэх мэтийн зvйлс байна. Энэ вйл хэрэгт борооны усны томор хоолой хvртэл татагдан орсон нь нэн сонирхолтой. Тэдгээрийг бомбор болон ёочин гэх мэт Монгол vндэсний цохиурт хогжмийг орлуулан яг байгаа чигээр нь ашиглаж, гайхам сайхан аялгуу тоглох аж. Ийн тоглож байгаа нь надад “

Gorg

” хэмээх эртний нийлмэл хогжмийг санагдуулав.

Хамтлагт орох хvvхдvvдийг яггvй чанга шалгуур хvлээдэг гэнэ. Шалгаруулах комисс тэдний хогжмийн сонсгол, гар хурууны уян болоод “хатлаг” чанарыг нь нарийн шинжиж байж сонгож авсан байна. Одоо тус хамтлаг хаа ч бардам алхахуйц урын сантай болжээ.Биднийг очиход оркестр сургуулилж байсан богоод. Бидэнд зориулан “Катюша”, “Подмосковные вечера” бас нэг гадаадын эстрад дуу, тэгээд мэдээжийн хэрэг Монгол ардын аялгуу тоглож vзvvлэв. Хамтлагийнхан долоо хоногт гурван удаа хоёроос дээш цагаар сургуулилт хийдэг гэнэ. Эгшиглэнт чимээ хамтлагийнхан маань онгорсон жил Улаанбаатарт болсон олон улсын хогжмийн наадамд очиж оролцон, тэргvн байранд шалгарч 100.0 сая тогрогийн шагнал хvртжээ. Тоглож буй хогжмийн зэмсэг хэрэгсэлvvдээ 45 тоглогч нэгэн зэрэг тоглохуйц тайзанд тохируулан бэлтгэж, сэлбэж, додомдох, онго зvс оруулах хийгээд заалны тvрээс сэлтийг ч бодолцож зохион байгуулдаг юм байна.



Монголын осворийн хогжимчид маань энэ онд Оросод болох “Цэнхэр шувуу”, /Синяя птица / хог жмийн наадамд оролцохоор толовложээ. Тэд одоо шаардлагатай баримт материал

зэргээ бэлтгэж байгаа бололтой.

Бидэнтэй цуг уг хамтлагийнхантай уулзсан Монголын Үндэсний их сургуулийн профессор Наваанзоч Х.Цэдэв хэлэхдээ “Монгол Оросын хоорон дахь хvмvvнлэг, соёлын чиглэлийн харилцаа, холбоо идэвхтэй орнох боллоо. Тэр чинээгээр сурган хvмvvжvvлэх салбарт маань осолт дэвшил гарах боломжтой юм. Манай хvvхэд залуус орос хэлийг сонирхон судлах, Оросын их дээд сургуульд элсэн суралцах нь мэдэгдэхvйц эрчимтэй болж байна. Манай сургуулиас хэд хэдэн оюутан Горно-Алтайск хотод их сургуульд суралцсан бол одоо Василий Шукшиний нэрэмжит Бийскийн Боловсролын акедмид эрдмийн зэрэг горилж буй суралцагсад ч нэлээд хэд бий” хэмээсэн. Үvнтэй холбогдуулж хэлэхэд ОХУ-ын Алтайн Бvгд найрамдах улсын нийслэл болон Монголын Баян-Олгий аймгийн дунд сургуулиудын хооронд солилцооны хотолбор хэрэгжvvлж, багш сурагчдыг харилцан зочлуулж буй гэх мэт хамтын ажиллагаа явагдаж буй билээ. Дархан хотын хvvхдvvдийн хамтлаг Орос улсад айлчлан тоглосноор тэндэхийн соёл, зан, заншил, хорш орны ард иргэдийн аж байдалтай танилцах бас нэгэн дэвшилттэй алхам болох нь дамжиггvй.

Хэвлэлд бэлтгэсэн Дмитрий СОКОЛОВ

Орчуулсан Г.Тормонх

Борооны усны хоолойноос “Катюша” эгшиглэнэ

Бичсэн тууш

2017 оны 5-р сарын 15, Даваа гариг, 13:29

